



“ТАНАН ЗҮҮ” ХХК

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 13-р хороо,
Алтантэвш хороолол, Дүүрэг 15-р гудамж, 587 тоот. Танан зүү ХХК байр
Утас: 91919964, 86109964 E-mail: tananzuu@gmail.com.

2026 оны 03 –р сарын 03 өдөр

Улаанбаатар хот

Компаний товч танилцуулга

Бид 2007 онд хувцас захиалгын чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд 2009 онд “Аракнидс” ХХК-компаниа байгуулж, ажлын болон дүрэмт хувцас, зөөлөн оёдлын үйлдвэрлэл, гадаад дотоод худалдааны чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байгаад одоо “Танан зэт” ХХК, “Танан зүү” ХХК-ууд болж өргөжин үйл ажиллагаа явуулж байна.

Манай компани үйлдвэрийн 750м² өөрийн байртай, нэрийн 2 дэлгүүртэй, үндсэн 30 гаруй ажилтантай, орон нутгийн 1, Улаанбаатар хотод 3 дагуул үйлдвэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Нэрийн дэлгүүртээ 4 улирлын, 100 гаруй загварын бүтээгдэхүүнийг өнгө болон материалын сонголттойгоор 42-60 (XS-6XL) размераар тогтмол үйлдвэрлэж бэлэн борлуулж байна.

Бид 18 жилийн турш төрийн болон хувийн хэвшлийн ААН, ОУ-ын байгууллагуудад өвөл зуны ажлын болон хөдөлмөр хамгааллын хувцас, дүрэмт хувцас зэргийг үйлдвэрлэн нийлүүлсээр байна. Манай бүтээгдэхүүнийг амжилттай ашиглаж ирсэн байгууллагууд

“МИАТ”ХК, ЗГХА-ЭХГазар, СБДЗДТГ, ЭХХТөв, “ДЦС-З”ТӨХК “УБЦТС”ХК, УБТЗ ХНН, “Монгол шуудан” ХК, Улаан загалмай нийгэмлэг, АDB төслүүд, ОСНААУГ, “Сод Монгол Групп”ХХК, ИНЕГ-ГТҮА, “GEM International”LLC, MCS, Энержи ресурс ХХК, Эрдэнэс тээвэр нэгдэл ХХК, “Таван толгой түлш”ХК, “Хөтөл цемент шохой” ХХК, УББҮК, “Хүннү эйр” ХХК, Баян-Өлгий ЦШСГ, “Хавцгайт их хайрхан” ХХК Баянхонгор хот тохижилт, Каппэ бэнэ Монголия, ОБ пластик, Монос косметикс, МҮОНРТ, ТТС&T LLC, FYTC LLC, Шувуун харуул ХХК, УНТөв 1-р эмнэлэг, 1-р төрөх гэх мэт.

Бид үндсэн хүчин чадлаараа сард 2000-2500 хос зуны хувцас үйлдвэрлэх хүчин чадалтай.

Өнгөрсөн хугацаанд үйлдвэрлэлээ чанаржуулснаар Стандарт Хэмжилзүйн Газараас олгодог ТОХИРЛЫН ГЭРЧИЛГЭЭ –ний болзлыг хангаж салбартаа анхны тохирлын гэрчилгээтэй компани болсон байдаг. Үүнд:

- 2015 онд Цэцэрлэгийн хүүхдийн гудас MNS 6553:2012,
- 2015 онд Цэцэрлэгийн хүүхдийн хөнжил, цагаан хэрэглэл MNS 6554:2012 стандарт
- 2018, 2025 онд Тусгай зориулалтын дулаан хувцас MNS 6306:2012 стандарт
- 2018, 2025 онд Тусгай зориулалтын ажлын хувцас MNS 6231:2011, MNS ISO 13688 : 2000

2020 оноос эсгүүр зохион бүтээлтийн BOK CAD программ нэвтрүүлж бүтээгдэхүүний гарц, эсгүүр, зохион бүтээлтийн төрөл, чанарыг нэмэгдүүлээд байна.

2022-2025 онуудад Оёдлын холбооноос санаачлан Цэцэрлэгийн биеийн тамирын хувцас кластераар үйлдвэрлэх “Найзууд” төслийн үндсэн зохион байгуулагч, толгой үйлдвэрээр ажиллаж 32 үйлдвэрлэгчийг зохион байгуулалтанд оруулж, уг төслийн хүрээнд 40000 иж бүрдэл буюу 120000ш бүтээгдэхүүнийг нийслэлийн 160, орон нутгийн 21 цэцэрлэгт амжилттай үйлдвэрлэн нийлүүлж чаджээ. Мөн ОУ-ын “Эхлэл”ТББ-ын захиалгын дагуу 2022-2025 онуудад жил бүр 1000 хүүхдийн өвлийн куртикийг үйлдвэрлэн нийлүүлэх төсөлд хамтран бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлж ажиллаад байна. Дээрх хүүхдийн төслүүд 2026 онд мөн үргэлжилж байна.

Цаашдаа шинэ технологи, инноваци шингэсэн автомат тоног төхөөрөмжийг нэвтрүүлж, импортыг орлох, экспортын баримжаатай оёмол бүтээгдэхүүн хувцас үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулах зорилттой ажиллаж байна.

Үнэт зүйл: Чанартай бүтээгдэхүүн чадварлаг хамт олон

Эрхэм зорилго: Итгэл төгс сонгох хувцас бидний бүтээл

Алсын хараа: Дэлхийн хувцасны хэрэглээнд бүтээгдэхүүнээ нэвтрүүлэх

